# Санхүүгийн зах зээлд оролцогч талууд, тэдгээрийн чиг үүрэг

Нийгэм судлал 10-р анги

Багш Д.Уранцэцэг

Утас: 99291533

# Хичээлийн зорилго

Эх сурвалжийг судлан, санхүүгийн зах зээлд оролцогч талууд, тэдгээрийн чиг үүргийг ялгаж, уялдаа холбоог бүдүүвчээр харуулах

# Тулгуур ойлголтууд

- Санхүүгийн хэрэгслүүдийг (үнэт цаас, мөнгө) худалдах, худалдан авах замаар сул чөлөөтэй байгаа мөнгөн хөрөнгийг эргэлтэнд оруулах, зээлийн эх үүсвэрийг бий болгох үйл ажиллагаа явагдаж байгаа зах зээлийн нийлбэр цогцыг санхүүгийн зах зээл гэнэ.
- Хувьцаа-Хөрөнгө оруулсан буюу хувь нийлүүлсэн болохыг гэрчилдэг үнэт цаас юм. ХК   Хязгаарлагдмал хариуцлагатайК
- Бонд-Зээл олгосон болохыг гэрчилж буй үнэт цаас юм.
- 1.Батлан даагч
- 2.Их хэмжээтэй мөнгө
- 3.Хүүний эргэн төлөгдөх нөхцөл уян хатан


Санхүүгийн зах зээлийн үүрэг
Санхүүгийн зуучлалын
Эрсдэлээс хамгаалах
Хадгаламж, хуримтлалыг төвлөрүүлэх
Төлбөрийн чадварыг хангах
Санхүүжилтын эх үүсвэрээр хангах

# Санхүүгийн зах зээлийн хүчин зүйлс

## Хөрөнгө оруулагчид

- Иргэд
- ААН
- ЗГ

## Зуучлагчид

- Брокер
- Дилер
- Хөрөнгө оруулалтын зөвлөх
- Үнэт цаасны компани
- Хөрөнгийн бирж
- **Андеррайтер**

## Санхүүжигчид

- Пүүс, компани
- Орон нутгийн засаг захиргааны байгууллага
- Санхүүгийн байгууллагууд

# Санхүүгийн зах зээлийн бүтэц



## Тест

1. Хувьцааны давуу талуудад орохгүй зүйл дурдсан бол аль нь вэ?

A. Хувьцааны ханш унаж болно B. Ногдол ашиг авах C. Инфляцид өртөхгүй D. Хөрвөх чадвар сайтай

2.Өгөгдлийг зөв харгалзуул

| | | | |
|---|---|---|---|
| 1 | Брокер | А | Ашиг олох зорилгоор өөрийн хөрөнгөөр үнэт цаас худалдан авах, худалдах арилжих ажиллагаа |
| 2 | Дилер | Б | Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний дагуу үнэт цаасны тухай танилцуулга бэлтгэх, шинээр болон нэмж гаргаж байгаа үйл ажиллагаа |
| 3 | Андеррайтер | В | Үнэт цаасны зах зээл дээр бусдын нэрийн өмнөөс үнэт цаасыг зуучлан худалдах, худалдан авах ажиллагаа |

3.Төв банкны гол үүрэгт аль нь багтах вэ?

A. Олон улсын банкуудтай холбоотой ажиллах B. Мөнгөний бодлого хэрэгжүүлэх

C. Мөнгөн хадгаламж авах D. Худалдааны газруудтай тооцоо хийх E. Бүгд зөв

4.Үнэт цаас зах зээлд гаргах үйл ажиллагааг үнэт цаасны ............................ гэж нэрлэнэ.

5. Мөнгө ямар нөхцөлөөс болж үүссэн бэ?

A. Барааг мөнгөөр солиход B. Мөнгөний ханш тогтооход C. Барааг хэмжиж тоолоход

D. Бараа солилцооны ханш тогтооход E. Барааг бараагаар солилцох үед

6. Ханш уналтаас ямар зүйл хамгаалж чаддаг вэ?

A. Мөнгөн хуримтлал B. Үл хөдлөх хөрөнгө үнэт цаас C. Найдвартай хүнд зээлдүүлсэн мөнгө

D. “Голомт” банкинд хадгалуулсан мөнгө E. Элгээрээс өөр

# Гэрийн даалгавар

1.Дээрх тестийн зөв хариултыг олж дэвтэртээ бичээрэй.

2.Санхүүгийн зах зээлд оролцогч талууд, тэдгээрийн чиг үүргийг ялгаж, уялдаа холбоог сурах бичгийн 91-93-р хуудаснаас сайтар уншаад гол ойлголтуудыг дэвтэртээ бичээрэй.Учир нь дараагийн хичээлээр Санхүүгийн зах зээлд холбогдох мэдээлэлд динамик судалгаа хийж, дүгнэлт гаргах тул онолын мэдлэгээ бататгах хэрэгтэй.